

ЗАВХАН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН



2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд цахим үйлчилгээг нэвтрүүлж, байцаагч ажилтнуудын мэдлэг чадвар, бүтээлч сэтгэлгээ, идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар нийгмийн даатгалын үйлчилгээний чанар үр нөлөөг дээшлүүлэх, нийгмийн даатгалын ерөнхий хууль хэрэгжилтийг хангуулах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах зорилтыг ханган ажиллалаа.

НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Хүний нөөцийн талаар

НДЕГ-ын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/51 дугаар тушаалаар батлагдсан 50 орон тоонд багтаан үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд шилжүүлэн томилогдсон 2, ажлаас чөлөөлсөн 8, хүүхэд асрах чөлөөтэй байгаад ажилдаа эргэн томилогдсон 1, түр орлон гүйцэтгэх 2 нийт 13 албан хаагчийг томилж чөлөөлөхдөө төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн. Одоо нөхөгдөөгүй байгаа албан тушаалын 5 сул орон тооны мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, нийтэд зарлуулсан.

Үүнд газрын газрын 4 орон тоо, Сантмаргаз сумын Нийгмийн даатгалын байцаагчийн 1 болно. Дээрх суманд зэргэлдээ сумдын байцаагчийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулж байгаа байсан бөгөөд төрийн албаны зөвлөлийн сонгон шалгаруулалтын дагуу нөхөгдөж одоо Сантмаргаз сумын Нийгмийн даатгалын байцаагчийн албан тушаалын орон тоо сул байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар болон бусад холбогдох байгууллагуудад хүний нөөцтэй холбоотой 12 судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2023 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргавал зохих 27 ажилтнаас хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь 100% гаргуулан авч нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан “ХАСХОМ мэдүүлэх нь” сэдэвт цахим сургалтанд нийт ажилтнуудыг хамруулсан. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны “Журам, маягт, жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 5 дугаар тогтоолыг танилцуулах сургалтанд хамрагдсан. Улсын байцаагчийн эрх авч албан тушаалын ангилал зэрэглэл нь өөрчлөгдсөн 4 ажилтны, сэлгэн болон шилжин ажиллах 4 ажилтны хувийн ашиг

сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулан Авлигатай тэмцэх газраар хянуулан томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан авч хуулийн хугацаанд тайлагнан ажилласан.

Ажилтан албан хаагчдын гаргасан ашиг сонирхлын мэдэгдэл тайлбарыг meduuleg.iaac.mn болон shilendans.gov.mn сайтад тухай бүр байршуулсан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай, Аймгийн засаг даргатай, байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг хүргүүлсэн.

1.2 Бичиг хэрэг, архивын талаар

Сумдын нийгмийн даатгалын тасгаас 2870 тэтгэврийн хувийн хэрэг, эмнэлгийн хуудас, тэтгэмжийн материал, шимтгэлийн болон бусад бичиг ирснийг бүртгэж хүлээн авсан, газрын байцаагч, ажилтнуудаас 3097 албан бичиг болон бусад бичиг баримт бичгийг сумдад хүргүүлсэн байна.

НДЕГ-аас ирүүлсэн хугацаатай 37 бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох байгууллагад хүргүүлсэн. Сумдын байцаагчдад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах 27 удаагийн зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

Аймгийн ЗДТГ-аас болон бусад байгууллагаас ирүүлсэн 320 тушаал, албан бичиг, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЗДТГ-аас хэлтэс агентлагийн дарга нарт зохион байгуулдаг шуурхай хурлын 9 удаагийн мэдээллийг ажилтнуудад хүргэн, цаг үеийн чухал ажлын талаар мэдээлэл хүргэх зорилгоор сумдын байцаагчдад ZOOM программаар, газрын байцаагчдад танхимаар мэдээллийн цагийг 5 удаа зохион байгуулж, арга зүйгээр ханган ажилласан.

Тэтгэвэр тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэл, хөдөлмөрийн чадвар алдалт, сайн дурын даатгал болон бусад асуудалтай холбоотой 87 өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж байна. Үүнээс 11-11 төвөөс шилжүүлэн ирсэн 5 өргөдөл байна.

НДЕГ-т сар бүрийн 10-ны өдрийн дотор НДЕГ-т өргөдөл гомдлын мэдээг хүргүүлж, тайланг 1 удаа хүргүүлэн ажилласан.

“Албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн баримтын архивт хүлээн авах хуваарь”-ийг гаргаж газрын даргын 2024.02.02-ны өдрийн А/04 тоот тушаалаар баталж хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: 2023 оны НДШ 43, СДД-ын 37, түр хадгалагдах 49, байнга хадгалах 34 хадгаламжийн нэгжийг архивласан.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас ирүүлсэн 191 архивын лавлагааны хүсэлтийг Able программаар хүргүүлсэн.

Аймаг дүүргүүдэд архивын лавлагаа авахаар хүргүүлсэн 33 хүсэлтийн хариуг хүлээн авч цахимаар 224 лавлагааг солилцож, иргэд даатгуулагчдад олгосон байна.

Дотооддоо иргэд даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 443, аж ахуй нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 185, АЖТДШНТухай хуульд хамрагдсан 54, QR-кодоор 467, нийт 1149 лавлагааг иргэд даатгуулагчдад олгосон.

Тэтгэвэр авч байгаад нас барсан, зогсоогдсон 210 тэтгэврийн хувийн хэргийн баримтын бүрдлийг мэдээллийн баазтай тулган шалгаж архивт шилжүүлсэн.

ББНШКомисс 4 удаа хуралдаж дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

1. Газрын үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгүүдийн хадгалах хугацааны жагсаалтыг хянаж, магадлан шалгах, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулахдаа байнга болон түр хадгалах хэргийг тус тусад нь ангилан төрөлжүүлсэн байдал, хөтлөх хэргийн хадгалах хугацааг зөв тогтоосон эсэхийг шалган хэлэлцсэн

2. Бичиг хэрэг хүний нөөцийн ажилтнаас архивлагддаг баримтуудыг нягтлан шалгасан

3. Сантмаргаз сумын Хүн эмнэлэг-1995, ЗДТГ-1996-1998 онуудын НДШ ийн нөхөн бүрдүүлсэн тайланг хянаж, шалган хэлэлцсэн

4. Отгон сумын төсөвт байгууллагуудын 1995-1997 оны баримт, Тэс сумын Арцсуурь дахь гаалийн хорооны 1995-2001 оны баримт, Эрдэнэхайрхан сумын төсөвт байгууллагуудын 1995—1997 оны цалингийн баримтууд

5.Цэцэн-Уул сумын мал эмнэлэг үржлийн албаны 1996 оны нөхөн тайлан, Эрдэнэхайрхан сумын Цэцэрлэгийн 1999 оны нөхөн тайлан, Улиастай сумын 3 дугаар цэцэрлэгийн 1995, 1999-2000 оны НДШ-ийн нөхөн тайлангуудыг хянан,хэлэлцэж архивт хүлээн авсан.

1.3 Засгийн газрын шийдвэрийн дагуу зохион байгуулсан ажлын талаар

Засгийн газрын тогтоол 3, НДҮЗ-ийн тогтоол 4, ХНХСайдын тушаал 13, НДЕГазраас ирүүлсэн 127 албан бичгээс тушаал 43, хууль хэрэгжүүлэх зөвлөмж 25, журам 2, чиглэл 23 байна.

Аймгийн ЗДТГ-аас болон бусад байгууллагаас ирүүлсэн 320 тушаал, албан бичиг, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж ирсэн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд нэг мөр ойлголт өгөх, аймгийн ЗДТГ-аас хэлтэс агентлагийн дарга нарт зохион байгуулдаг шуурхай мэдээллийг хүргэх, цаг үеийн чухал ажлын талаар мэдээлэл хүргэх зорилгоор сумдын байцаагчдад ZOOM программаар, газрын байцаагчдад танхимаар мэдээллийн цагийг 10 удаа зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

Нийгмийн даатгалын тухай багц хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоох, олгох, тэдгээрт хяналт тавих ажлыг зохион байгуулж,тайлант хугацаанд шинээр тэтгэвэр тогтоолгохоор өргөдөл гаргасан өндөр нас 521, хча 153 тэжээгчээ алдсаны 50, нийт

724 тэтгэвэр авагчийн хувийн хэргийн баримт бичгийг мэдээллийн баазад тулган шалгаж тэтгэврийг цаг хугацаанд нь тогтоон олгосон.

Тайлант хугацаанд тэтгэвэр тогтоолгосноос хойш ажил хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 206 тэтгэвэр авагчийн тэтгэврийн өөрчлөн тогтоосон.

Шилжиж ирсэн 4, шилжин явсан 32 тэтгэвэр авагчдын үндсэн мэдээллийг мэдээллийн баазад хянаж баталгаажуулсан.

Арилжааны банкуудтай байгуулсан гэрээний 3.1.6-д заасны дагуу сар бүр олгох тэтгэврийг тэтгэвэр авагч бүрээр тооцон сар бүрийн ажлын сүүлийн өдрийн 10 цагаас өмнө тэтгэвэр олгох жагсаалтыг хүргүүлж байна

2024 оны 01 сарын 01 өдрөөс хэрэгжсэн Нийгмийн даатгалын багц хуулийн дагуу 6,7 жилийн цалингийн дунджаар тэтгэврээ тогтоолгосон 1852 тэтгэвэр авагчдын тэтгэврийг 5 жилийн цалингийн дунджаар өөрчлүүлэх хүсэлтийг хүлээн авч, 1140 тэтгэвэр авагчийн тэтгэврийг өөрчлөн тогтоож, олгосон.

Эрүүл мэндийн байгууллагаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсэн болон амаржсаны эмнэлгийн хуудас цахимаар илгээгдсэн нийт 2119 даатгуулагч, ажилгүйдлийн тэтгэмж авахаар цахимаар хүсэлтээ ирүүлсэн 392 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч тэтгэмжийг хянаж баталгаажуулан олгож байна. Тэтгэмж авагчдын 98,8 хувь нь цахимаар хүсэлтээ илгээж хэвшсэн.

Монгол хэлний тухай хуулийн 7, 24 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-г хэрэгжүүлэн ажиллах хүрээнд ажилтнуудыг НДЕГазраас зохион байгуулж байгаа сургалтанд хамруулах нөхцөл боломжоор ханган ажиллаж байна.

1.4 Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар

1. Складанд хадгалагдаж байгаа эд хогшил хөрөнгийг шинэ, хуучин, актлагдах зэргээр нь ялган агуулахын өрөөний эмх цэгцийг сайжруулсан.



2. Газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/12 тоот тушаалаар бичиг хэрэг хүний нөөц дотоод асуудал хариуцсан мэргэжилтнээс архивлагддаг баримтуудыг эмхлэн цэгцэлж, архивын нэгж болгон хөтлөх хэргийн жагсаалтын дагуу хүлээлгэн өгсөн.



3. Газрын 1-3 давхрын заалны хана, коридор, 2 өрөөний дотор талыг албан хаагчид өөрсдийн хүчээр эмульдэж, өнгө үзэмжийг сайжруулсан.





4. Газрын гаднах хаяг, байцаагч ажилтнуудын өрөөний хаягийг НДЕГазраас ирүүлсэн стандартын дагуу хийж байршуулсан.



5. Газрын байцаагч ажилтнууд ажлын байранд цагаан буюу цэнхэр өнгийн цамц, хар, хар хөх өнгийн юбка өмдөөр жигдрэн иргэдэд үйлчилгээ үзүүлж байна.



6. Газрын конторын галын аюулгүй байдал осол гэмтлээс хамгаалан галын аврах гарцын бүдүүвч зургийг шинэчлэн хийлгэж байршуулсан.



7. Газрын 1 давхрын коридорын хэсэгт ханын шүүгээ хийлгэн байгууллагын шагнал, цом, өргөмжлөлийг нийтэд сурталчилан шинэчлэн байгуулсан.



8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн даатгалын үйлчилгээ авах боломж нөхцөлийг хангах зорилгоор гадна паднус шинээр бариулж ашиглалтад оруулсан.



9. “Цахим хөтөч”-ийг газрын үйлчилгээний зааланд байрлуулж иргэд даатгуулагчдад мэдээлэл хүргэн ажиллаж байна.



10. Газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд Үйлчлэгч ажилтны хувьцасыг шинэ загвараар хийлгэсэн..



11. Газрын ажилтнууд нийгмийн даатгалын лого бүхий бомбор /куртика/ захиалан жигдэрсэн. Эв нэгдэл сэтгэл ханамж илэрхийлсэн аялал болон хөдөө орон нутагт ажиллахдаа өмсөж байна.



12. Ажилтнуудын санаачлагаар цайны булан байгуулахыг байгууллагын зүгээс дэмжиж кофе чанагч болон бусад зүйлээр дэмжиж ажилласан.



13. Байгууллагаас гарах хог хаягдлыг ангилж ялган хаях зориулалтын хогийн савыг шинээр ашиглалтад оруулсан. Монгол бичгийн аяныг дэмжиж 2 давхрын үйлчилгээний зааланд “Цаг” захиалан хийлгүүлж байрлуулсан.



14. Монгол бичгийн аяныг дэмжиж “Цаг” захиалан ашиглаж байна.



15. Нийгмийн хамгааллын ажилтны өдрийн тохиолдуулан Завхан аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газраас зохион байгуулсан спортын олон төрөлт тэмцээнд түрүүлж цомоор шагнагдсан.



ХОЁР. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ ОЛГОЛТЫН ТАЛААР

13021 тэтгэвэр авагчдад 55 140 691.3 мянган төгрөгийн тэтгэврийг хуульд заасан хугацаанд бүрэн олгосон.

ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТОО 13035



Өндөр насны тэтгэвэр авагч

10626



Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч

1628



Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч

457



Цэргийн алба хаасны болон ТД, ТА

309



ҮОМШӨ-ний ТД, ТА тэтгэвэр авагч

15

Шинээр тэтгэвэр тогтоолгохоор өндөр насны 521 иргэн, хөдөлмөрийн чадвар алдсаны 153 иргэн, тэжээгчээ алдсаны 50 иргэн нийт 724 иргэн хүсэлтээ ирүүлж тэтгэвэр тогтоолгон авч байна.

ТЭТГЭМЖ АВАГЧДЫН ТОО 2811




**ХЧТА ны
тэтгэмж**

562



**Жирэмсний болон
амаржсаны тэтгэмж**

1557



**Нас барагчийн
ар гэрт олгох
тэтгэмж**

285



**Ажилгүйдлийн
тэтгэмж**

407

Тэтгэмжийн даатгалын сангаас 2404 даатгуулагчид 5 495 899.3 мянган төгрөгийн тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас 407 даатгуулагчид 1 279 506.6 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон. Шинэ систем нэвтэрч байгаатай холбоотой НДЕГ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдан байцаагч ажилтнуудын программ хангамж ашиглах видео хичээл бэлтгэн сумдын байцаагчдад цахимаар болон танхимаар мэдээллийг хүргэн ажиллаж байна.

Идэвхтэй тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэргийн тооллогыг хийх ажлын хэсгийг хагас бүтэн жилээр тоолох томилон 2 удаа тооллогыг хийсэн. өндөр насны-10859, хөдөлмөрийн чадвар алдсаны-1674, тэжээгчээ алдсаны- 502, нийт-13035 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг тэтгэврийн массивтай тулган шалгаж, тооллогыг хийн ЗН-НД-6, ЗН-НД-7 маягтаар нэгтгэхэд тэтгэврийн хувийн хэрэг болон хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт бичиг дутагдсан зөрчил илрээгүй.

Шинээр тэтгэмж тогтоолгох болон тэтгэмж авахаар хүсэлт ирүүлсэн Хөдөлмөрийн чадвар алдсаны 562, ажилгүйдлийн тэтгэмж 407, жирэмсэн амаржсаны тэтгэмж 1557, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж 285 нийт 2811 даатгуулагчийн материалыг мэдээллийн баазад хянан оруулж, олголт үүсгэн тэтгэмж олгосон.

ГУРАВ: ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ТАЙЛАН

2024 оны 03 сарын 19-ны өдөр Нийгмийн хамгааллын бүлгийн тушаал гишүүдийн тушаалыг шинэчлэн зохион гаргасан. Нийгмийн хамгааллын бүлгийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан аймгийн онцгой байдлын газраар батлуулсан.

2024 оны 03 сарын 28-ны өдөр аймгийн онцгой байдлын газраас зарлан дуудах дохиог ажиллуулж нийт нийгмийн хамгааллын бүлгийн бэлэн байдлыг шалгаж, баг бүрэлдэхүүн бэлэн жагссан.



Хүн ам, нийгмийн хамгааллын улсын албанд “Команд штабын сургууль”-ийг 2024 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулсан. “Команд штабын сургууль” хийхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч, бэлтгэл ажлыг хангасан.

Сургууль хийх өдрүүдэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа удирдлагуудтай хамт Нийгмийн хамгааллын бүлгийн гишүүд нэг байранд байрлан цахимаар холбогдон, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангаж, өгөгдсөн өгөгдөл дээр ажилласан.





ДӨРӨВ. МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН

Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/03 тоот тушаалыг тус зөвлөлд шинээр томилогдон ажиллах гишүүдэд танилцуулан ажилласан.

Тус зөвлөл нь энэ онд Газрын дэргэдэх Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн хурлыг 9 удаа хуралдуулж, 23 хүний өргөдлийг авч хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн асуудлаар-3

Малчнаар ажилласан жилээ тогтоолгох асуудлаар-17

Хөдөлмөрийн хөнгөлөлттэй нөхцөлийн холбогдолтой асуудлаар-2

Бусад асуудлаар-1

Мөн тус зөвлөлийн хурлаас тогтоолоор-17, тоотоор 6 хүнд хариу өгч ажилласан.

Зөвлөлийн гишүүдэд Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдон гарсан зөвлөмж, зааврыг тухай бүр нь танилцуулан ажиллаа.





**ТАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ, ШИМТГЭЛИЙН ӨР АВЛАГЫН БАРАГДУУЛАЛТ, НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХАМРАЛТЫН ТАЛААР**



**Ажил олгогчийн
тоо
767**



**Даатгуулагчийн
тоо
12471**



**Сайн дурын
даатгуулагчийн тоо
5278**



**Малчин
3488**

Аймгийн Татварын хэлтсээс 2023 болон 2024 онд шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн судалгааны дагуу хамралтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлах тухай” 2024 оны 02 сарын 28 ны өдрийн А/ 39 дугаар тушаалын хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газраас арилжааны банкуудаар олгож буй “Ажлын байрыг дэмжих” хөнгөлттэй нөхцөлөөр зээл олгохдоо “Нийгмийн даатгалд хамрагдсан байх” гэсэн шалгуур тавьж ажилласны үр дүнд шинээр 83 аж ахуйн нэгж байгууллагын 808 иргэдийг албан журмын даатгалд хамруулсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 42160485.0 мянган төгрөг, гүйцэтгэл 45027397.9 мянган төгрөг 106.8 хувиар биелүүлсэн.

Шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сан тус бүрээр харуулбал:

Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэврийн сан	36 390 397.6	39 093 079.3	107.2
Тэтгэмжийн сан	2 205 799.1	3 340 442.7	104.2
Ажилгүйдлийн сан	1 081 638.6	1 115 169.4	103.1
ҮОМШӨ сан	1 482 649.7	1 548 706.5	104.5
Дүн	42 160 485.0	45 027 397.9	106.8

Орлогын бүтцийг авч үзэхэд 4 сангийн төлөвлөгөө нэр төрлөөрөө бүрэн биелсэн байна.

Сангийн зарлага сан тус бүрээр харуулбал:

Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэврийн сан	112 287 729.6	112 049 603.4	99.8
Тэтгэмжийн сан	5 495 899.3	5 495 899.3	100.0
Ажилгүйдлийн сан	1 279 506.6	1 279 506.6	100.0
ҮОМШӨ сан	223 215.8	222 769.3	99.8
Дүн	119 286 351.3	119 047 778.6	99.8

Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулахаар төлөвлөгөө гарган газрын даргаар баталж ажиллаж байна. Тус төлөвлөгөөг нийт ажилтнуудад танилцуулан газрын албан хаагч 4-6 ажил олгогч хариуцан ажиллаж байна. Тухайн хариуцсан ажил олгогч руу утсаар болон биеэр уулзалт зохион байгуулж, шимтгэлийн ертэй ажил олгогчдод өрөө барагдуулах, алданги тооцох тухай, нийгмийн даатгалын сангаас ажилтнуудад тэтгэвэр, тэтгэмж олгохгүй тухай мэдэгдлийг хүргүүлэн ажиллаж байна.

Оны эхний НДШ-н авлагатай 191 байгууллагын 869721.5 мянган төгрөгнөөс 178 байгууллагын 765140.6 мянган төгрөг буюу нийт авлагын 87.9 хувийг бүрэн барагдуулсан.

Шүүхийн шийдвэртэй байсан 1 ажил олгогч буюу Ойн баялаг ХХК-ийн 1546.0 мянган төгрөгийг авлагыг барагдуулах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай хамтран ажиллаж бүрэн барагдуулсан.

31-90 хоногийн насжилттай шимтгэлийн өртэй ажил олгогчдод Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу өр барагдуулах албан мэдэгдлийг 109 ажил олгогчид хүргүүлж, 108 байгууллагад утсаар ярьж сануулан ажиллаж байна.

91-180 хоногийн насжилттай шимтгэлийн өртэй 190 ажил олгогчдын банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох тухай мэдэгдлийг хүргүүлэн дансыг түр хааж, үүнээс шимтгэлээ төлсөн 175 ажил олгогчийн дансны зарлагын гүйлгээг нээж ажилласан.

181-270 хоногийн насжилттай шимтгэлийн өртэй 35 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж авлага барагдуулах гэрээ байгуулсан.

271 ба түүнээс дээш хоногийн насжилттай шимтгэлийн өртэй 40 ажил олгогчийг хуулийн байгууллагад шилжүүлж, эзэн холбогдогч нь олдохгүй байгаа 3 ажил олгогчийн удирдлагыг шүүхээр эрэн сурвалжуулах шийдвэр гаргуулж, 3 ажил олгогчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн ажилласан.

2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05/779 албан бичгийн дагуу ажил олгогч даатгуулагчаас тайлан, гэрээ засах 44 албан бичгийг үндэслэн цуцалж, засаж илгээсэн тайланг эхнээс нь шалгаж баталгаажуулсан. Сайн дурын даатгалын гэрээний эхлэх хугацаа болон гэрээний дүн буруу хийгдсэн 75 даатгуулагчийн гэрээг цуцалж засварласан.

Нийгмийн даатгалын 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан. Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар 25041.5 мянган төгрөгийн зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн тайлант хугацаанд зөвлөмжид дурьдсан зөрчил гаргаагүй байна. Зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь <https://fas.audit.mn/>-д оруулан тайлагнасан.

Арилжааны банктай байгуулсан гэрээнд өдөр бүрийн үлдэгдэлд хүү тооцон 65201.8 мянган төгрөгийг хүүгээр бүртгэсэн. Тэтгэвэр тавьж олгосны банкны үйлчилгээний хөлсөнд 6085.9 мянган төгрөг шилжүүлсэн.

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАЛААР

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны 01/105 тоот чиглэлийн дагуу даатгуулагчид төлбөл зохих шимтгэлийн хэмжээг тооцож, шимтгэлээ Ebarimt- цахим төлбөрийн баримтын системээр төлүүлэх талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.

ЭМД-ын харилцах дансуудыг 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс ашиглахгүй болсонтой холбоотойгоор НДЕГ-т 1881.4 мянган төгрөгийг төвлөрүүлэн, уг харилцах дансыг хаасан. ЭМД-ын ташаарсан 316 даатгуулагчийн 6609.7 мянган төгрөгний орлогын жагсаалтыг гаргаж баталгаажуулан НДЕГ-т хүргүүлэн ажилласан.

ДОЛОО. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР

Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/20 дугаартай тушаалаар мэдээлэл байршуулах болон хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилсон.

2024 оны байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг “shilen.gov.mn”-д хуульд заасан хугацаанд байршуулсан.

2024 оны жилийн эцсийн байдлаар “Шилэн дансны хууль”-ийн хэрэгжилтэд аудит хийж гүйцэтгэсэн. Шилэн дансны цахим хуудсанд “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу тайлант хугацаанд тусгай зориулалтын сангийн мэдээллийг 171 удаа мэдээлэхээс хугацаандаа 171, Газрын үйл ажиллагааны зарцуулалтын мэдээллийг 182 удаа мэдээлэхээс хугацаандаа мэдээлсэн 182 байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй ба бүрэн мэдээлсэн.

НДЕГ-ын даргын 2023 оны А/69 дүгээр тушаал “ Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай”-ын дагуу 7 арга хэмжээ 27 ажил үйлчилгээ бүхий төлөвлөгөө газрын даргаар батлуулан ажиллан 2024 оны эхний хагас жилийн байдлаар НДЕГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалтаар 531,2 сая төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоогдсоноос 306,8 сая төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 58,1 хувьтай байна.

Дотоодын хяналт шалгалтаар 104,1 сая төгрөгийн төлбөрөөс 72,8 сая төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 70,1 хувьтай байна.

Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойших хугацаанд хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхчүүдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар 9 ажил олгогчийн 15 даатгуулагчийн өргөдлийн дагуу “Гомдол мэдээлэл хүлээн авахаас татгалзсан” хэрэг үүсгэн аймгийн прокурорын байгууллагаар хянуулан хууль заасан хугацаанд шийдвэрлэсэн бөгөөд хугацаандаа төлөгдөөгүй 3,690.5 мянган төгрөгийн шимтгэл болон түүнд ногдох алдангийг “Зөрчлийн талаарх гомдол, мэлээллийг хүлээн авахаас татгалзсан материал” хүлээн авч шийдвэрийг Прокурорын байгууллагаар хянуулан хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлсэн. “Зөрчлийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.17.4 дахь заалтын дагуу 2 ажил олгогчид 500,0 мянган төгрөгийн торгууль ногдуулан төлбөрийг бүрэн барагдуулсан. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт ханган ажиллаж байна. Аймгийн прокурорт сар бүр мэдээгээ гарган хүргүүлсэн. Мөн оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх хугацаанд “Нийгмийн даатгалын тухай” хуульд заасны дагуу даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй орхигдуулсан 32 ажил олгогчийн 39 даатгуулагчийн өргөдлийн дагуу шалган Улсын байцаагчийн актаар 6,133.8 мянган төгрөгийн төлбөр зөрчлийг тогтоон бүрэн барагдуулсан.

Программын шинэчлэлтэй холбоотой “цахим хяналтын веб програм” <http://10.9.0.5/monitoring>-д 2024 оны зөрчилтэй байх магадлалтай мэдээлэл эхний хагас жилийн байдлаар байршаагүй байгаа тул хянах боломжгүй байна.

Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч нь эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт, төлөвлөгөөт хяналт шалгалт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 479 дүгээр тогтоолын дагуу хийж гүйцэтгэсэн.

Эрсдэлийн үнэлгээний талаар: Нийгмийн хамгааллын салбарын хяналтын нэгдсэн удирдамжийн дагуу их, дунд эрсдэлтэй 15 объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөгдсөн. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 онд 4 чиглэлээр хийж 07.3.1 кодтой “Ажилтны нийгмийн хамгааллыг шалгах хяналтын хуудас”-аар аж ахуй нэгж байгууллагуудын санхүүгийн баримт, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хөдөлмөрийн болон иргэнтэй байгуулсан гэрээнүүдийг хамруулан шалгаж эрсдэлийн болон хууль сахин мөрдөлтийн түвшинг үнэлэн гүйцэтгэсэн.

1. 2024.02.07-ны өдрийн 13-07/04 дугаартай Хөнгөн хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Бүрдийн баян бүрд ХХК, Загасан нүд Загастай ХХК, Марал тун далай ХХК, Эрхэм оргил ХХК зэрэг аж ахуй нэгж байгууллагуудын хууль сахин мөрдөлт 70%, эрсдэл үүсэх магадлал 29.2% байна. Эдгээр аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг шалгахад нийт 34 зөрчил илэрч хяналт шалгалтын явцад холбогдох хууль, журмын дагуу заавар зөвлөгөө өгч арилгуулсан.

2. 2024.02.07-ны өдрийн 13-07/05 дугаартай Зам тээврийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа Завхан Азза ТӨХК, Жавхлант хийморь хоршоо, Жигд эргэлт ХХК зэрэг 3 аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийхэд 20 зөрчил илэрч, хууль сахин мөрдөлт 76%, эрсдэл үүсэх магадлал 25% байна. Илэрсэн зөрчил дутагдлыг улсын байцаагчийн албан шаардлагаар барагдуулж ажилласан.

3. 13-07/06 дугаартай уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Түүчээ тэрэг ХХК, СДД / Вестерн монголиа девелопмент/ ХХК, Форс Голд Майнинг ХХК зэрэг 3 аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт өгөхөд 7 зөрчил илэрч хууль сахин мөрдөлт 80%, эрсдэл үүсэх магадлал 12% байна. Форс Голд Майнинг ХХК 2021 оны 05 сараас үүссэн 38,7 сая төгрөгийн авлагыг НДШ-ийн авлага барагдуулах уулзалтын гэрээ байгуулан харъяа Чингэлтэй дүүргийн НДГ-т шилжүүлсэн.

4. 13-07/10 дугаартай барилга угсралт, завсар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Бэрсүм ХХК, Зуурмаг ХХК, Хан жаргалант стоунс ХХК зэрэг 3 аанб-ын үйл ажиллагааг шалгахад 34 зөрчил илэрснийг шалгалтын явцад арилгуулж, хууль сахин мөрдөлт 50%, эрсдэл үүсэх магадлал 41 % байна. Цаашид илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар заавар зөвлөгөө өгч зөвлөн туслаж ажилласан. Дээрх чиглэлүүдээр хийсэн ажлын гүйцэтгэлийг хугацаандаа хийж гүйцэтгэн хуваарийн дагуу холбогдох газарт хүргүүлсэн.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар: Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэхэд зөрчил илрээгүй бөгөөд тайланг хугацаанд НДЕГазрын хяналт шалгалтын газарт хүргүүлсэн.

НАЙМ. ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ТАЛААР:

Тус зөвлөл нь нийгмийн даатгалын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, ЭММТөв зөвлөл ирүүлсэн зөвлөмж, чиглэлүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, комиссын эмч нарын сонгон шалгаруулалтыг зохион байгуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 10 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж бичиг баримтанд үндэслэн, цахимаар болон иргэд даатгуулагчдыг байлцуулан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг богиносгох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэн долоо хоног бүрийн пүрэв гаригт хуралддаг.

Тайлант хугацаанд 7 хоног бүрийн пүрэв гаригт нийт 41 удаагийн хурлыг зохион байгуулсан. 1986 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадалснаас 236 хүнийг шинээр тогтоож, 1529 хүний сунгаж, 220 цуцалсан, 1 хөдөлмөрийн нөхцөл сольсон, 22 шилжиж явсан, 2 шилжиж ирсэн, 108 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг оношийн үндэслэл, оношлогоо, шинжилгээ хангалтгүй шалтгааны улмаас буцаасан шийдвэр гаргасан. Мөн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаагаа сунгуулаагүй 6 сар болсон иргэдийн хөдөлгөөнийг сар бүр хийж, 71 иргэнийг өөрт болон асран хамгаалагчид мэдэгдэн цуцлах хөдөлгөөн хийсэн.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоолгосон 1680 хүн нийгмийн даатгалын сангаас, 1042 хүн нийгмийн халамжийн сангаас тус тус тэтгэвэр авч байна.

Хувь хэмжээгээр хагас (хэсэгчлэн) алдсан буюу 50-69 хувиар алдсан 1723, бүрэн алдсан буюу 70-100 хувьтай 1002 иргэн байна.

Даатгуулагч (иргэн)Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох шийдвэрүүдийг гаргахдаа Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/441, А/192 тоот тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна.

Завхан аймагт Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөл бүрдмэл болон хамтарсан магадлал зохион байгуулагдаагүй байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалттай 2770 тэтгэвэр авагч иргэн байсан нь өмнөх оны үлдэгдлээс 1.6 хувиар буурсан буюу 2725 тэтгэвэр авагч байна.




2024 оны эхний хагас жилийн байдлаар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгож, бүртгэгдсэн өвчлөлийн түвшингээр аймгийн хэмжээнд эхний 5 байранд зонхилон тохиолдож байгаа ХЧА-ын шалтгааныг авч үзвэл:

1.	Сэтгэц болон зан үйлийн эмгэг өвчин	650	23.9 хувь
2.	Гэмтэл согогийн өвчин	494	18.1 хувь
3.	Дотрын өвчин	383	14.1 хувь
4.	Мэдрэлийн өвчин	378	13.8 хувь
5.	Нүдний өвчин	311	11.4 хувь
6.	Бусад өвчлөл	510	18.7 хувьг тус

тус эзэлж байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтыг графикаар авч үзвэл



Засгийн газрын тогтоол 1, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал 2, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 3 албан тоот, зөвлөмж зааврыг тухай бүр болон эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд танилцуулан хэрэгжүүлэн ажилласан. Мөн иргэдээс ирсэн 3 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг цаг тухай бүрт нь Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн программд бүртгэн, хурал бүрийн дараа цахим эмнэлэг хөдөлмөрийн программд хурал бүрийн дараа мэдээллийн баазыг тавьж тэтгэвэр авагчдад чирэгдэл үүсгэлгүй ажилласан.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлан гишүүн тус бүрээс хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр авч дүгнэв. Дүнгийн хурал дээр цаашид анхаарч ажиллах асуудлуудын талаар зөвлөлийн гишүүдтэй санал солилцон ажилласан.



Зөвлөлийн гишүүдийг удирдлага арга зүйгээр хангах болон иргэдэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор “Завхан ЭММЗөвлөл” нэртэй фейсбүүк групп нээн эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, дүрэм, зөвлөмж болон эмнэлгийн хуудасны бичилт олголттой мэдээлэлийг оруулан иргэд даатгуулагчтай холбогдон ажиллаж байна.

ТАХИР ДУТУУГИЙН ТЭТГЭВЭР

Хөдөлмөрийн чадвараа алдсаныг тогтоолох:

- Аймаг, сум, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, шалтгаан, хугацааг тогтооно.

Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа алдалтын хувийг:

- 70 ба түүнээс дууш хувиар тогтоосон бол хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсанд
- 50-69 хувиар тогтоосон бол хөдөлмөрийн чадвараа

Завхан аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөл >

Нууцлалтай бүлэг · 136 гишүүн

Удирдах Урих

Та Чаатууд Онцлох Зураг Арга

Ямар нэг юм бичих...

Нэргүй нийтлэл Сэтгэл санаа Сана

Завхан аймгийн Эрүүл...

ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

legalinfo.mn
Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

14 хүн харсан

Таалагдлаа Сэтгэгдэл Илгээх

А. Цэрэнлхам
Админ · 50мин ·


<http://www.gadpwd.gov.mn/index.php/page/746>
Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм

gadpwd.gov.mn
ХБХХЕГ

13 хүн харсан

Таалагдлаа Сэтгэгдэл Илгээх

Увс аймгийн сайн туршлага болох 1856 хүний амбулаторийн картыг өвчний оношоор өөр өөр өнгөөр ялган мэдээллийг шинэчлэн өнгө үзэмжийг сайжруулсан, Архангай аймагт зохион байгуулагдсан “Процессын дахин инженерчлэл” сургалтад Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын магадлагч эмч Нийгмийн халамжийн төлөөллүүд оролцох үеэр тус аймгийн хурлын явцтай танилцаж хурлын онцлог давуу талуудыг судалж амбулаторийн картны нүүр хэсэгт иргэний цээж зургийг байрлуулах сайн туршлагыг 2023 онд нэвтрүүлэн үргэлжлүүлэн ажиллаж байна.



Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн байдалд дүн шинжилгээ хийсэн.


1. Завхан аймгийн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийг нийт хүн амд харьцуулсан судалгааг гаргахад 3.8 хувь байна. 38.3 хувь нь Нийгмийн халамжийн сангаас, 61.7 хувь нь Нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар 2770 байсан бол 2024 оны байдлаар 2725 болж өмнөх оноос 1,6 хувиар буурсан байна.

2. Өнгөрсөн 5 жилийн байдлаар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ тогтоолгосон иргэдийн хувь тогтмол буурсан үзүүлэлттэй байсан. Өвчний ангиллаар эхний 5 байрыг авч үзвэл Сэтгэц болон зан үйлийн эмгэг, Гэмтэл согогийн өвчин, Дотрын өвчин, Мэдрэлийн өвчин, Нүдний өвчин байна.

3. Сум тус бүрээр өвчний ангиллаар авч үзсэн судалгааг гаргасан.

Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд оролцогч талуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх ижил мэргэжилтний үзлэгийг Говь-алтай аймагт Говь-алтай, Завхан, Ховд, Увс аймгийн эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн магадлагч эмч, төрөлжсөн 3 мэргэжлийн эмч нарыг оролцуулан 2024 оны 09 сарын 24-ний өдөр зохион байгууллаа. Ижил мэргэжилтний үзлэгт нийт 60 картыг хамруулж Говь-алтай, Завхан, Ховд аймгийн 40 иргэний картыг хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэх үеийн дүгнэлт болон оношийн баталгаажилтыг хянах шалгуур хуудсаар үнэлж ажиллахад үнэлгээний хувь-89, ололттой тал, илэрсэн зөрчил дутагдлыг тусгаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг боловсруулан үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.








Сургалтууд

1. 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн орлогч дарга, магадлагч эмч нар хяналтын эмч нарт Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож буй засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал, Эмнэлгийн хуудас олгох, хянах журам сургалтыг аймгийн нэгдсэн эмнэлгийн хяналтын эмч нарт хийсэн.

2. Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газартай хамтран “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт цахим сургалтанд Завхан аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 8 гишүүн оролцсон.



3. 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр “Авлигын гэмт хэрэг, түүний ойлголт” сэдвээр АТГ-ын комиссар М.Жамъяачойжил, Р.Төрбулаг нарын цахим сургалтад Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга, магадлагч эмч нар хамрагдсан.

4. 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Б.Сансарбаяр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд болон хяналтын эмч нар нийт 11 хүн хамрагдав. 2024 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр аймгийн Прокурорын газрын ахлах прокурор Б.Сансарбаяр “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтад Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд болон хяналтын эмч нар нийт 11 хүн хамрагдав.



5. 2024 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр Говь-алтай аймагт “Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход оролцож байгаа анхан шатны эмч нарыг чадавхжуулах” баруун бүсийн сургалтад Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн магадлагч эмч, мэс заслын эмч, аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрийн нар оролцсон.



6. 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Хүний эрхийн комиссын завхан дахь референт Ч.Наранхүү “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх” сэдвээр хийсэн сургалтад тус зөвлөлийн 8 гишүүн, Хяналтын 38 эмч хамрагдав.



ЕС. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР

Сургалт сурталчилгааны тоон тайлан

Д/д	Хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээ	Ажил үйлчилгээний тоо	Хамрагдсан даатгуулагчийн тоо /давхардсан тоогоор/
1	Ажил олгогчид зориулсан сургалт	89	2013
2	Гар утасны аппликейшн суулгасан тоо	1	380
3	Нээлттэй хаалганы өдөрлөг	14	5541
4	Явуулын үйлчилгээ	7	479
5	Газрын байцаагч ажилтнуудад зориулсан сургалт, зөвлөгөөн	24	504
6	Фэйсбүүк хуудасны хандалт, дагагчийн тоо	256	83300


1. Тус газрын 2024 онд албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшлүүлэх сургалт 24 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 504 ажилтанг цахимаар болон танхимаар хамруулсан НДЕГазар, АЗДТГазар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн комисс, Прокурорын газар

2. Ажил олгогч иргэд даатгуулагчдад зориулсан сургалтыг 89 удаагийн сургалтаар 2013 иргэд даатгуулагч хамруулсан. Үүнд:




1. Нээлттэй хаалганы өдөрлөг 14 удаа, хүний тоо 5541
2. Явуулын үйлчилгээ 7 удаа, хамрагдсан хүний тоо 479
3. Газрын социал хуудас, веб хуудсаар постер мэдээлэл бэлтгэн түгээсэн 256 удаа, хүний тоо 83300, дагагч 3317

Байцаагч ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх дотоодын сургалт, зөвлөгөөн


Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам сэдэвт сургалт



Ажил олгогчийн тайлан илгээх талаарх сургалт




Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих, зөрчлийг шалгахад анхаарах асуудал сэдэвт сургалт



Төрийн албаны шинэтгэл, ёс зүйн тухай хууль тогтоомжийн чиглэлээрх сургалт




Ажлын байрны дасгал хөдөлгөөн



Гамшгаас хамгаалах сургалт



Баримт бичгийн стандарт сэдэвт сургалт








Татварын тухай хууль болон татварын тайлан гаргахад анхаарах асуудал сэдэвт сургалт



Цахимд хэвшье




Сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан



Хөдөлмөр нийгэм хамгааллын яам



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын гамшгаас хамгаалах команд штабын сургууль



Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд орсон сургалт



АРАВ. АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТАЛААР

1. Тус байгууллагаас 2024 онд нэг удаагийн буцалтгүй тусламж болох 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг авах хүсэлт гаргасан 2 албан хаагчийн 72861.7 мянган төгрөгийн тэтгэмж төсөвт суулган олгохоор шийдвэрлэгдсэн.

2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023.06.08-ны өдрийн А/88 дугаар “Унаа, хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн “Унаа хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/135 тоот тушаалаар батлагдсан унаа хоолны мөнгийг батлагдсан төсөвтөө багтаан газрын 24, сумын 26 албан хаагчдад 61858.2 мянган төгрөгийг олгосон. 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн Б/14 тоот Аймгийн засаг даргын захирамжаар 18 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдлийг олгож байна.

3. Үр бүтээлтэй ажилласан 14 байцаагч, ажилтныг холбогдох хууль журмын дагуу шагнаж урамшуулахаар тодорхойлж, шийдвэрлүүлэхээр баримт бичгийг бүрдүүлж НДЕГ-т хүргүүлсэн. “Хөдөлмөрийн хүндэт медаль” –иар 1 ажилтан, ХНХЯамны “Хөдөлмөрийн тэргүүний ажилтан”-аар 1 ажилтан тус тус шагнагдсан. Ажилтнуудын хагас жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлж 80209.2 мянган төгрөгийн урамшуулал олгосон.

4. Хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний эрт илрүүлгийн шинжилгээнд Газрын 36 эмэгтэй байцаагч ажилтан албан хаагчдаас 16 албан хаагч хамруулж, 15 байцаагч, ажилтангийн хариу хэвийн, 1 байцаагчаас хавдрын сэжигтэй тохиолдол гарсныг хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 5 хоногийн цалинтай чөлөө олгож, ХСҮТ-д эмчилгээнд хамруулсан. 2 ажилтан Улаанбаатар хотод дараагийн шатны эмнэлэгт үзүүлэхээр эмчилгээ оншлогоо хийлгэхэд 5-10 хоногийн

цалинтай чөлөө олгосон байна. 12 дугаар сард Засгийн газар, ЭМЯамнаас зохион байгуулж байгаа эрт илрүүлэг, үзлэг оншилгоонд тус газрын 29 албан хаагчид аймгийн нэгдсэн эмнэлэгт үзлэгийн цаг аван нэгдсэн журмаар хамруулсан. Мөн 9 байцаагч ажилтан эмнэлэгт хэвтэхэд хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн цалинг олгосон байна.

5. Газрын гэр хороололд амьдардаг 5 албан хаагчид түлээ нүүрсний 1275.0 мянган төгрөгийг хөнгөлөлтийг олгосон. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдсан Б.Ууганзаяа, Ю.Ням-Очир нарт 2700.0 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж, ЭММЗ-ийн бүрэлдэхүүнд 3-аас дээш жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан магадлагч эмч А.Цэрэнлхамд нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг 2 удаа буюу нийт 2904.0 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон.

6. Улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах шалгалт өгөх албан хаагчдыг сумаас дуудан ирүүлж газарт байрлуулан нэгдсэн журмаар шалгалтад балтгэх нөхцөл боломжийг бүрдүүлж, сургалт хийсэн.

ДУГНЭЛТ

Тайлангийн хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилтууд хэрэгжиж, шинэ хуулийн үйлчлэлээр тэтгэвэр тэтгэмж авах иргэдийн тоо өсч, хамралтыг нэмэгдүүлэх аяны үр дүнд малчдын нийгмийн даатгалын хамрагдалт нэмэгдэж, иргэд даатгуулагчдад хүргэх үйлчилгээний чанар , иргэдийн цахим үйлчилгээ, мэдээ мэдээллийг хүлээн авах чадвар дээшилж бүх архивын лавлагаа, эмнэлгийн хуудас цахим хэлбэрт шилжсэнээр бүх төрлийн цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо өссөн байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газраас цахимаар зохион байгуулж буй бүх төрлийн сургалтууд, сумдын байцаагчдыг чадавхжуулах сургалт үр дүнтэй байж, авлага барагдуулах, сайн дурын даатгалын хамралт, сургалт сурталчилгааны шинэ арга барил, Засгийн газрын 1111 төвд ажиллаж иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж байгаа туршлага шинэ санааг өгсөн Ерөнхий газрын Удирдлагын багтаа талархал илэрхийлье.

ТАЙЛАН БИЧСЭН:

ГАЗРЫН ДАРГА

С.НЯМЖАВ